



БУЛГАН АЙМГИЙН БУЛГАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ЭЭЛЖИТ
XI ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар XI/06

Булган сум

Сумын Засаг даргын “Ирээдүйд
тэмүүлсэн хот” хөтөлбөрийн 2022 оны эхний
хагас жилийн хэрэгжилтийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 8 дахь удаагийн сонгуулийн XI хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын Засаг даргын “Ирээдүйд тэмүүлсэн хот” хөтөлбөрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилтийг хэлэлцээд “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлсүгэй.

2. Сумын Засаг даргын “Ирээдүйд тэмүүлсэн хот” хөтөлбөрийн үйл ажиллагааг холбогдох хууль, эрх зүйн хүрээнд үр дүнтэй зохион байгуулж, сумын иргэдэд болон иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж ажиллахыг сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д үүрэг болгосугай.

3. Сумын Засаг даргын “Ирээдүйд тэмүүлсэн хот” хөтөлбөрийн 2022 оны эхний хагас жилийн хэрэгжилт 77.1 хувийн биелэлттэй буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдсэн тул Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д сарын үндсэн цалингийн 40 хувиар урамшуулал тооцож олгохыг Тамгын газрын дарга (Ч.Балдандорж)-д зөвшөөрсүгэй.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Удирдлага зохион байгуулалтын Хорооны дарга, гишүүдэд даалгасугай.

ДАРГА  Б.ГАНЗОРИГ

